



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2025/004/НА-СТА-ТТЗ

Чингис хот
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунаа
Утас: 99195208 Цахим хаяг: ariunaab@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторун дүгнэлт.....	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	11
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР**

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.03.25 № 500
танай _____ -ны № _____ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН БАЯН-ОВОО
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Н.ЦОЛМОНБАЯР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн сумын Засаг даргын харьяаны иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 50,547.3 мянган төгрөгийн, Засаг даргын тамгын газрын 537,300.8 мянган төгрөгийн нийт 587,848.1 мянган төгрөгийн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс их бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

Засаг даргын тамгын газар нь орон нутгийн төсвийн татварын бус орлогыг Төрийн бус байгууллагын данс, байгууллагын нэмэлт дансанд төвлөрүүлэн зарцуулсан, нөөцийн барааны өвс, тэжээлийг анхан шатны баримтгүй зарлагадсан, НДШ-ийн тайланд цалин дутуу тайлагнасан, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, түлш халаалтын зардлыг илүү төлсөн, шилэн дансанд мэдээлбэл зохих мэдээллийг дутуу мэдээлсэн, төрийн захиргааны албан хаагчийн сул орон тоо гарсан тухай бүрд олон нийтэд нээлттэй мэдээлэх, төрийн албаны нөөцөөс нөхөх арга хэмжээ аваагүй байна.

Иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж, шилэн дансны нэгдсэн системд мэдээллийг дутуу байршуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”,

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.2-т "орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх;" Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.", Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.9-д "Сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ:", 23.9.2-т "орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого;", 35 дугаар зүйлийн 35.2-т "Төсвийн байгууллага нь төвлөрүүлсэн төсвийн орлого болон өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна.", Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т "Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ.", Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр"-ийг долоо хоногийн дотор мэдээлнэ, Эрчим хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11-д "халаалтын улирал эхлэх, дуусах огноог тогтоох", Эрчим хүчний сайдын 2021.07.22-ны А/129 тоот тушаалаар батлагдсан "Халаалтын улирал эхлэх, дуусах огноог тогтоох тухай"-ын "В"-д "... Хэнтий ... аймгуудын төвлөрсөн болон төвлөрсөн бус дулаанаар хангагддаг эмнэлэг, сургууль, цэцэрлэг, орон сууцны халаалтын эхлэх хугацааг тухайн оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөр, дуусах хугацааг дараа оны 05 дугаар сарын 15-ны өдрөөр, бусад аж ахуйн нэгж байгууллагуудын халаалтын эхлэх хугацааг 10 дугаар сарын 01-ний өдрөөр, дуусах хугацааг дараа оны 05 дугаар сарын 01-ний өдрөөр" гэж заасныг зөрчиж, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант оны төсвийн санхүүжилтийн эх үүсвэрийг орон нутгийн төсвийн орлогоос 532,594.0 мянган төгрөг, аймгаас авах санхүүгийн дэмжлэгээс 1,383,387.8 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгээс 545,487.9 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 30,000.0 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 440,750.3 мянган төгрөг нийт 2,932,220.0 мянган төгрөгөөр бүрдүүлэхээр баталжээ.

Төсвийн тодотголоор аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 402,919.9 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг 172,796.6 мянган төгрөгөөр бууруулж, орон нутгийн төсвийн орлогыг 34,300.0 мянган төгрөгөөр, урьд үлдэгдлийг 343,518.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж нийт 2,700,022.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн авч 2,044,886.3 мянган төгрөгийг зарцуулж, 289,695.7 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Сумын Засаг даргын харьяа байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,390,354.8 мянган төгрөгийн 21 алдаа, зөрчил илрүүлснээс 683,447.4 мянган төгрөгийн 9 алдааг санхүүгийн тайланд аудитын явцад залруулж, 11,824.3 мянган төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 695,083.1 мянган төгрөгийн зөрчилд 8 албан шаардлага хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд нийт 98,585.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1,956.8 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, 3,804.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 25,376.7 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 67,448.2 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өглөө.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын хүрээнд 48 арга хэмжээг төлөвлөж, 83.2 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан****/мянган төгрөгөөр/**

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,025,301.36	1,174,837.69
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	757,949.23	823,726.72
3	1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	193,358.03	208,609.47
4	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	73,994.11	120,901.51
5	1.1.6 НӨӨЦИЙН БАРАА	9а	-	21,600.00
6	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		6,342,583.73	6,298,729.71
7	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	6,342,583.73	6,298,729.71
8	1.2.2.02 Биет хөрөнгө		6,130,937.73	6,087,143.71
9	1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	211,646.00	211,586.00
10	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		7,367,885.09	7,473,567.40
11	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР		177.97	343,576.19
12	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		177.97	343,576.19
13	2.1.1.03 Өглөг		177.97	343,576.19
14	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		7,367,707.12	7,129,991.21
15	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		7,367,707.12	7,129,991.21
16	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		339,285.57	339,285.57
17	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		6,741,093.39	6,503,377.49
18	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		287,328.15	287,328.15
19	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		7,367,885.09	7,473,567.40

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		3,176,360.34	2,552,741.35
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО		753,321.25	729,388.20
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар		409,365.37	408,065.41
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар		409,365.37	408,065.41
5	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар		80,857.65	105,557.27
6	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		263,098.23	215,765.52
7	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	799,315.49	1,823,353.16
8	1.1.1.04.3 Тусламжийн орлого		-	985,043.41
9	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,623,723.60	-
10	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	1,827,594.78	2,120,497.44
11	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ		1,827,594.78	2,120,497.44
12	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,788,321.24	2,082,846.68
13	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		598,845.44	868,285.62
14	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		74,824.06	108,695.58
15	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		385,538.11	405,271.73
16	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		56,366.76	38,163.36
17	1.1.2.01.1.05 Нормативт зардал		862.60	-
18	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		78,847.8	61,405.28
19	1.1.2.01.1.07 Томилот, зочны зардал		17,974.00	15,825.00
20	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		109,362.36	105,686.03
21	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		465,700.11	479,514.08
22	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		39,273.53	37,650.76
23	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		1,348,765.56	432,243.91
24	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		403,685.75	668,340.25
25	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		(403,685.75)	(668,340.25)
26	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		945,079.81	(236,096.34)

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан
/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,409,289.40	2,151,983.82
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	753,321.25	729,388.20
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	409,365.37	408,065.41
4	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	80,857.65	105,557.27
5	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	263,098.23	215,765.52
6	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	19,420.37	17,860.48
7	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	75,321.82	71,438.16
8	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	168,356.04	126,466.88
9	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	32,244.55	1,422,595.63
10	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	32,244.55	28,125.52
11	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	-	1,021,778.71
12	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	372,691.40
13	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,623,723.60	-
14	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,440,950.87	1,753,844.27
15	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,440,950.87	1,753,844.27
16	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,397,177.33	1,715,893.51
17	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	599,175.78	864,702.67
18	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,797.27	107,958.41
19	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	385,538.11	405,271.73
20	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	38,027.94	30,437.17
21	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	1,512.60	-
22	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	70,644.65	67,274.55
23	1.1.1.2.01.1.07 Томилот, зочны зардал	17,974.00	15,825.00
24	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	130,096.61	142,293.47
25	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	75,410.37	82,130.51
26	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,773.53	37,950.76
27	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	968,338.53	398,139.55
28	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	679,591.04	292,362.07
29	1.1.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	679,591.04	292,362.07
30	1.1.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	679,591.04	292,362.07
31	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-679,591.04	-292,362.07
32	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	40,000.00
33	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	(40,000.00)
34	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	288,747.50	65,777.49
35	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	469,201.74	757,949.23
36	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	757,949.23	823,726.72

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,422,627.30		6,422,627.3
2	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,422,627.30		6,422,627.3
3	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	945,079.81		945,079.81
4	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,367,707.12		7,367,707.12
5	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	7,367,707.12		7,367,707.12
6	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(1,619.56)		(1,619.56)
7	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,366,087.55		7,366,087.55
8	1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-		-
9	1.7 Тайлант үеийн үр дүн	(236,096.34)		(236,096.34)
10	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	7,129,991.21		7,129,991.21

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,420,695.2	2,110,673.02
2	3.1.01.1.1 Татварын орлого	559,644.00	729,388.20
3	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	390,000.00	408,065.41
4	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	390,000.00	408,065.41
5	3.1.01.1.1.1.1.01 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	317,000.00	333,052.33
6	3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого	52,000.00	46,730.61
7	3.1.01.1.1.1.1.03 Хөрөнгийн орлого	18,000.00	25,232.46
8	3.1.01.1.1.1.1.04 Хөрөнгө борлуулсны орлого	3,000.00	3,050.00
9	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	91,200.00	105,557.27
10	3.1.01.1.1.3.1 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	20,000.00	23,498.67
11	3.1.01.1.1.3.2 Бууны албан татвар	1,200.00	1,260.00
12	3.1.01.1.1.3.4 Малд ногдуулах албан татвар	70,000.00	80,798.60
13	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	78,444.00	215,765.52
14	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	11,300.00	17,860.48
15	3.1.01.1.1.8.1.01 Улсын тэмдэгтийн хураамж	2,500.00	8,492.48
16	3.1.01.1.1.8.1.06 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	2,800.00	1,669.00
17	3.1.01.1.1.8.1.08 Хог хаягдлын үйлчилгээний хураамж	6,000.00	7,699.00
18	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	65,000.00	71,438.16
19	3.1.01.1.1.8.2.01 Газрын төлбөр	65,000.00	71,438.16
20	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	2,144.00	126,466.88
21	3.1.01.1.1.8.3.02 Ан амьтны нөөц ашигласны төлбөр	2,144.00	126,466.88
22	3.1.01.1.2 Татварын бус орлого	861,051.20	1,381,284.82
23	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	37,250.00	28,125.52
24	3.1.01.1.2.1.3 Торгуулийн орлого	5,250.00	5,431.00
25	3.1.01.1.2.1.4 Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	30,000.00	19,094.52
26	3.1.01.1.2.1.5 Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	-	3,600.00
27	3.1.01.1.2.1.9 Бусад орлого	2,000.00	-
28	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	451,109.80	980,467.90
29	3.1.01.1.2.3.3 Аймаг нийслэлээс авсан татаас	980,467.90	980,467.90
30	3.1.01.1.2.3.5 Төсвөөс санхүүжих	(529,358.10)	-
31	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	372,691.40	372,691.40
32	3.1.01.1.2.4.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	372,691.40	372,691.40
33	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	402,691.40	2,574,244.53
34	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	(289,680.60)	2,246,382.46
35	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,969,282.80	1,680,462.16
36	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	937,680.30	864,702.67
37	3.1.01.2.1.1.1.01 Үндсэн цалин	397,234.80	379,773.83
38	3.1.01.2.1.1.1.02 Нэмэгдэл	381,877.50	351,088.42
39	3.1.01.2.1.1.1.03 Унаа хоолны хөнгөлөлт	42,936.00	31,171.53
40	3.1.01.2.1.1.1.04 Урамшуулал	64,840.00	51,879.12
41	3.1.01.2.1.1.1.05 Гэрээт ажлын хөлс	50,792.00	50,789.77
42	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	116,960.00	107,958.41
43	3.1.01.2.1.1.2.01 Тэтгэврийн даатгал	79,532.80	74,107.67
44	3.1.01.2.1.1.2.02 Тэтгэмжийн даатгал	9,356.80	8,731.43
45	3.1.01.2.1.1.2.03 ҮОМШӨ-ний даатгал	4,678.40	4,518.19
46	3.1.01.2.1.1.2.04 Ажилгүйдлийн даатгал	4,678.40	4,275.63
47	3.1.01.2.1.1.2.05 Эрүүл мэндийн даатгал	18,713.60	16,325.50
48	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	547,987.50	405,271.73
49	3.1.01.2.1.1.3.01 Гэрэл, цахилгаан	93,489.80	63,746.43
50	3.1.01.2.1.1.3.02 Түлш, халаалт	436,066.70	340,475.30
51	3.1.01.2.1.1.3.03 Цэвэр, бохир ус	18,431.00	1,050.00
52	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	32,913.40	27,583.81
53	3.1.01.2.1.1.4.01 Бичиг хэрэг	4,910.70	4,135.90
54	3.1.01.2.1.1.4.02 Тээвэр, шатахуун	19,494.30	16,733.33
55	3.1.01.2.1.1.4.03 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,908.50	3,949.68
56	3.1.01.2.1.1.4.05 Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	245.00	96.00
57	3.1.01.2.1.1.4.06 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,354.90	2,668.90
58	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	1,807.10	-

59	3.1.01.2.1.1.5.03 Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,807.10	-
60	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	66,035.00	55,544.55
61	3.1.01.2.1.1.6.01 Багаж, техник, хэрэгсэл	3,105.80	-
62	3.1.01.2.1.1.6.02 Тавилга	3,178.80	-
63	3.1.01.2.1.1.6.03 Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	943.10	156.00
64	3.1.01.2.1.1.6.04 Урсгал засвар	58,807.30	55,388.55
65	3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	17,839.00	15,825.00
66	3.1.01.2.1.1.7.02 Дотоод албан томилолт	17,839.00	15,825.00
67	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	171,060.20	142,293.47
68	3.1.01.2.1.1.8.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	165,743.30	139,403.05
69	3.1.01.2.1.1.8.02 Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	961.70	-
70	3.1.01.2.1.1.8.03 Даатгалын үйлчилгээ	434.30	431.46
71	3.1.01.2.1.1.8.04 Тээврийн хэрэгслийн татвар	536.40	535.63
72	3.1.01.2.1.1.8.05 Тээврийн хэрэгслийн оношлогоо	245.60	32.50
73	3.1.01.2.1.1.8.06 Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,595.40	945.00
74	3.1.01.2.1.1.8.07 Газрын төлбөр	1,543.50	945.84
75	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	77,000.30	61,282.52
76	3.1.01.2.1.1.9.01 Бараа үйлчилгээний бусад зардал	70,559.40	58,205.32
77	3.1.01.2.1.1.9.02 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,440.90	3,077.20
78	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	(2,258,963.40)	565,920.30
79	3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг	(2,297,330.60)	529,358.10
80	3.1.01.2.1.4.1.03 Төсвийн санхүүжилт	(2,297,330.60)	529,358.10
81	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	38,367.20	36,562.20
82	3.1.01.2.1.4.2.06 Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,525.70	26,525.70
83	3.1.01.2.1.4.2.07 Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,260.00	7,186.50
84	3.1.01.2.1.4.2.08 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,581.50	2,850.00
85	3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	485,372.00	287,862.07
86	3.1.01.2.2.4 Бусад хөрөнгө	485,372.00	287,862.07
87	3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	207,000.00	40,000.00
88	3.1.01.2.3.1 Эргэж төлөгдөх зээл	207,000.00	40,000.00
89	3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	1,018,003.80	(463,571.51)
90	3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(1,018,003.80)	463,571.51
91	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(1,018,003.80)	463,571.51
92	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	757,938.92
93	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	823,725.51

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Аудитлагдсан дүн
I	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	34,810,807.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	34,810,807.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	33,210,090.08
2104	Хангамж, бараа материалын зардал	1,803,890.08
210402	Тээвэр, шатахуун	1,803,890.08
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,730,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,730,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,676,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,676,200.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,600,716.92
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	1,600,716.92
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	34,810,807.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	34,810,807.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,378,736.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	32,432,071.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Баян-Овоо сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа орон нутгийн төсвийн 2, улсын төсвийн 4 байгууллага, 1 төрийн сангийн, 3 тусгай сан нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс ЗДТГ-ын санхүүгийн тайланд аймаг дахь Төрийн аудитын газар аудит хийж “Хязгаарлалттай”, Хүүхдийн цэцэрлэг, ЕБС-ийн санхүүгийн тайланд Платиниум прогресс аудит ХХК аудитыг гэрээгээр гүйцэтгэж “Өөрчлөлтгүй” дүгнэлт тус тус өгсөн.

Сумын ИТХ, Хоршоо хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, Соёлын төв, Эрүүл мэндийн төв аудитын түүвэрт хамрагдсан болно.

3.1. Тус сумын харьяа орон нутгийн төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар 1,251,333.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 663,485.2 мянган төгрөгийн 8 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, 581,540.0 мянган төгрөгийн зөрчилд 8 албан шаардлага, 6,308.2 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт хүргүүлсэн. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

Санхүүгийн аудитын асуудлаар илэрсэн зөрчлийг байгууллагаар харуулбал:

Засаг даргын тамгын газар

1. НДШ-ийн 12 дугаар сарын тайланд 9 хүний цалинг 6,163.7 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.

2. Хадлангийн зориулалтаар айл, өрхөд 20 га, аж ахуйн нэгж байгууллагад 100 га газрыг ашиглуулахаар гэрээ байгуулж, төлбөрийг Эко Баян-Овоо ТББ-ын төрийн банкны 250501858879 тоот дансаар дамжуулан 166 айлын 16,650.0 мянган төгрөгийг байгууллагын нэмэлт төсвийн дансанд шилжүүлж, мөн дансанд 26 өрхөөс 2,600.0 мянган төгрөг, 3 аж ахуйн нэгжээс 3,121.5 мянган төгрөг нийт 22,371.0 мянган төгрөгийг төвлөрүүлэн зарцуулсан байна.

3. Тус байгууллага нь төрийн захиргааны албан хаагчийн сул орон тоо гарсан тохиолдолд олон нийтэд мэдээлэхгүйгээр төрийн сангийн мэргэжилтэнг 6 дугаар сараас СА-ны дарга, бэлчээр, тэжээл, газар тариалан хариуцсан мэргэжилтэнг 9 дүгээр сараас байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн, мал аж ахуй, үйлдвэрлэлийн технологи, үржил бүртгэлийн мэдээлэл хариуцсан мэргэжилтэнг 12 дугаар сараас хоршоо, жижиг дунд үйлдвэрлэл, хүнс хариуцсан мэргэжилтэнгээр түр орлон гүйцэтгүүлсэн байна.

Шийдвэрлэлт: Зөрчлийг таслан зогсоох 3 албан шаардлага хүргүүлсэн.

3. Бараа материалын тайлангийн нөөцийн бараа данснаас 4,900.0 мянган төгрөгийн өвс, тэжээлийг анхан шатны баримтгүй зарлагдсан.

4. Түлш халаалтын зардлыг 1,408.2 мянган төгрөгөөр илүү төлсөн.

Шийдвэрлэлт: Төлбөр барагдуулах 2 акт тогтоосон.

3.2 Тус сумын харьяа улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар 139,021.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 19,962.2 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, 113,543.1 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 5,516.2 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт хүргүүлсэн. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

Санхүүгийн аудитын асуудлаар илрэсэн зөрчлийг байгууллагаар харуулбал:

Ерөнхий боловсролын сургууль

1. Тайлант онд 17 ажилтанд ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүй 2,665.1 мянган төгрөгийн цалин давхардуулан олгосон байна.

Цэцэрлэг

2. Ээлжийн амралтын дундаж цалингийн дүнд "хоол унааны хөнгөлөлт"-ийг оруулж тооцон 2,851.1 мянган төгрөгийн цалин илүү олгосон.

Шийдвэрлэлт: Төлбөр барагдуулах 2 акт тогтоосон.

3.3 Сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 98,585.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1,956.8 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, 25,376.8 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 3,804.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 67,448.2 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлээ. Үүнд:

3.3.1 Төлбөрийн акт

1. Малын тоо толгойн албан татварын 3,804.2 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн хөгжлийн сангийн дансанд дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8-д "малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн даац тогтоох, бэлчээрийн төлөв байдлын үнэлгээ хийх, бэлчээр ашиглуулах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах, газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна." гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.3.2. Албан шаардлага:

1. Төрийн сангийн ерөнхий орлогын 2,100.0 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн 5,400.0 мянган төгрөг нийт 7,500.0 мянган төгрөгийн оны эхний үлдэгдлийг төсвийг санхүүжүүлэх эх үүсвэрт төлөвлөөгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх", 57.3-т "Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна." гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Баян-Овоо сумын ИТХ нь нийтээр дагаж мөрдөх "Сумын нутаг дэвсгэрт хадлангийн газар ашиглуулах журам"-ыг 2025 оны А/20 дугаар тогтоолоор баталсан захиргааны хэм хэмжээний актыг эрх бүхий байгууллагад хянуулж, бүртгүүлээгүй, журамд Төсвийн тухай хуулийг зөрчиж орон нутгийн төсвийн орлогыг Төрийн бус байгууллагын дансанд төвлөрүүлэхээр журамласан, зарцуулалтын талаар тусгаагүйгээс 17,876.8 мянган төгрөгийг зориулалт бусаар хяналтгүй зарцуулсан байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.6-д "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын баталсан захиргааны хэм хэмжээний актыг Засаг даргын хуульд

заасан хориг тавих хугацаа дууссанаас хойш ажлын таван өдрийн дотор эрх бүхий байгууллагад хянуулж, бүртгүүлэхээр хүргүүлнэ.", 67.2-т "Захиргааны хэм хэмжээний акт нь энэ хуулийн 67.1-д заасны дагуу нийтэлснээр хүчин төгөлдөр болно. Захиргааны хэм хэмжээний актад дагаж мөрдөх хугацааг өөрөөр зааж болно.", Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.9-д "Сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ:", 23.9.2-т "орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого;" 35 дугаар зүйлийн 35.2-т "Төсвийн байгууллага нь төвлөрүүлсэн төсвийн орлого болон өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна." гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.3.3 Зөвлөмж

1. Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийн авлагын үлдэгдэлд 15 зээлдэгчийн 128.0 сая төгрөг байгаагаас 5-аас дээш жилийн насжилттай 13 зээлдэгчийн 67.4 сая төгрөгийн зээлийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны А/361 тоот тушаалаар батлагдсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 7.3-т "Сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг сумын Засаг дарга хариуцан арилгах бөгөөд хөнгөлөлттэй зээлийг зориулалтын бусаар зарцуулсан, зээлийн гэрээнд заасан заалтыг зөрчсөн зээлдэгчийн зээлийн гэрээг цуцалж, зээлийг Сангийн дансанд буцаан төвлөрүүлэх ажиллагааг зохион байгуулна." гэснийг зөрчсөн байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн 5-аас дээш жилийн насжилттай үлдэгдлийг төлүүлэхэд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулагдаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ИТХ	1	931.1			1	931.1	1	931.1				
ЗДТГ	5	584,882.1	1	101,266.9	4	483,615.2	5	584,882.1				
ХХС	1	677.6	1	677.6			1	677.6				
ОНХС	1	76,994.4			1	76,994.4	1	76,994.4				
ОНТБ-ын дүн	8	663,485.2	2	101,944.5	6	561,540.7	8	663,485.2	0	0.00	0	0.00
Соёлын төв	1	19,962.2			1	19,962.2	1	19,962.2				
УТБ-ын дүн	1	19,962.2	0	0.0	1	19,962.2	1	19,962.2	0	0.00	0	0.00
Засаг дарга	1	1,956.8	1	1,956.8			1	1,956.8				
ТТЗ-ийн дүн	1	1,956.8	1	1,956.8	0	0.0	1	1,956.8	0	0.00	0	0.00
Дүн	10	685,404.2	3	103,901.3	7	581,502.9	10	685,404.2	0	0.00	0	0.00

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ИТХ	1	4,275.6			1	4,275.60						
ЗДТГ	5	34,842.9	2	6,308.2	3	32,810.3						
ОНБ-ын дүн	6	39,118.5	2	6,308.2	4	37,085.9	0	0.0	0	0.0	0	0.0
ЕБС	1	2,665.1	1	2,665.1								
Цэцэрлэг	1	2,851.1	1	2,851.1								
УТБ-ын дүн	2	5,516.2	2	5,516.2	0	-	0	0.0	0	0.0	0	0.0
Засаг дарга	4	96,629.2	1	3,804.2	2	25,376.8	1	67,448.2				
ТТЗ-ийн дүн	4	96,629.2	1	3,804.2	2	25,376.8	1	67,448.2	0	0.0	0	0.0
Дүн	12	141,263.9	5	15,628.6	6	62,462.7	1	67,448.2	0	0.0	0	0.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ИТХ	1	46,271.7			1	46,271.7		
ЗДТГ	1	462,458.0			1	462,458.0		
ОНТБ-ын дүн	2	508,729.7	0	-	2	508,729.7	0	-
Соёлын төв	1	113,543.1			1	113,543.1		
УТБ-ын дүн	1	113,543.1	0	-	1	113,543.1	0	-
Дүн	3	622,272.8	0	-	3	622,272.8	0	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ЗДТГ	1	40,000.0			1	40,000.0		
Дүн	1	40,000.0	0	0	1	40,000.0	0	0
Нийт дүн	4	662,272.8	0	-	4	662,272.8	0	-



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 85-А2370448
ХЭА-2026/004-НА-СТА-ТТЗ

Чингис хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Малын тоо толгойн албан татварын 3,804,200.00 (гурван сая найман зуун дөрвөн мянга хоёр зуу) төгрөгийн орлогыг орон нутгийн хөгжлийн сангийн дансанд дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8-д "малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн даац тогтоох, бэлчээрийн төлөв байдлын үнэлгээ хийх, бэлчээр ашиглуулах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах, газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.4-д "төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй." гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Малын тоо толгойн албан татварын 3,804,200.00 (гурван сая найман зуун дөрвөн мянга хоёр зуу) төгрөгийг Төрийн сан банк дахь ерөнхий орлогын 100181500910 тоот данснаас "Орон нутгийн хөгжлийн сан"-ийн 100181552400 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг сумын Засаг дарга Н.Цолмонбаярт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ж.ГАНБААТАР

Б.АРИУНАА



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 03 сарын 25

Дугаар 264- А2370448
ХЭА-2026/004/НА-СТА-ТТЗ

Чингис хот

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн сангийн ерөнхий орлогын 2,100,000.00 (хоёр сая нэг зуун мянга) төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн 5,400,000.00 (таван сая дөрвөн зуун мянга) төгрөг нийт 7,500,000.00 (долоон сая таван зуун мянга) төгрөгийн оны эхний үлдэгдлийг төсвийг санхүүжүүлэх эх үүсвэрт төлөвлөөгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх", 57.3-т "Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.5-д "төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг санхүүжүүлэх эх үүсвэрт урьд оны үлдэгдлийг бүрэн төлөвлөдөггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга Н.Цолмонбаярт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Б.АРИУНАА





ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25

Дугаар 265-А 2370448
ХЭА-2026/004/НА-СТА-ТТЗ Чингис хот

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баян-Овоо сумын ИТХ нь нийтээр дагаж мөрдөх "Сумын нутаг дэвсгэрт хадлангийн газар ашиглуулах журам"-ыг 2025 оны А/20 дугаар тогтоолоор баталсан захиргааны хэм хэмжээний актыг эрх бүхий байгууллагад хянуулж, бүртгүүлээгүй, журамд Төсвийн тухай хуулийг зөрчиж орон нутгийн төсвийн орлогыг Төрийн бус байгууллагын дансанд төвлөрүүлэхээр журамласан, зарцуулалтын талаар тусгаагүйгээс 17,876,800.00 (арван долоон сая найман зуун далан зургаан мянга найман зуу) төгрөгийг зориулалт бусаар хяналтгүй зарцуулсан байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.6-д "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын баталсан захиргааны хэм хэмжээний актыг Засаг даргын хуульд заасан хориг тавих хугацаа дууссанаас хойш ажлын таван өдрийн дотор эрх бүхий байгууллагад хянуулж, бүртгүүлэхээр хүргүүлнэ.", 67.2-т "Захиргааны хэм хэмжээний акт нь энэ хуулийн 67.1-д заасны дагуу нийтэлснээр хүчин төгөлдөр болно. Захиргааны хэм хэмжээний актад дагаж мөрдөх хугацааг өөрөөр зааж болно.", Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.9-д "Сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ:", 23.9.2-т "орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого", 35 дугаар зүйлийн 35.2-т "Төсвийн байгууллага нь төвлөрүүлсэн төсвийн орлого болон өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бус зарцуулах" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсвийн орлогыг төрийн бус байгууллагын дансанд төвлөрүүлэн зориулалт бусаар хяналтгүй зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг дарга Н.Цолмонбаярт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

АУДИТОР

Б.АРИУНАА